



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/05

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйл 23.5, 23.7 дахь хэсгүүд, Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ний өдрийн “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 417 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай” 02 дугаар тогтоол, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам” 03 дугаар тогтоол, Дундговь аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн “Бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай” А/04 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод дүн шинжилгээ хийж, шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батхүү (Аялал жуулчлал, гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Цэрэнсугир (Усны нөөцийн ашиглалт хамгаалалт, ойн бодлого, төрийн бус байгууллага, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн)

Т.Саранчимэг (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

А.Мөнх-Эрдэнэ (Биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газар нутаг, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн)

А.Ганцэцэг (Орчны бохирдол, химийн хорт бодис, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

М.Мөнхзул (Мэдээллийн сан, байгаль орчны төлөв байдал, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн)

Б.Бадрах (Дэл хөнжил, Цагаан суваргын Байгаль хамгаалагч)

А.Нэргүй (Ерөнхий нягтлан бодогч)

С.Хишигжаргал (Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав)

Нарийн бичгийн дарга: Б.Нямтуяа (Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, хөрсний доройтол (Цөлжилт), байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

2.“Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-д нийцүүлэн 2024 оны 02 дугаар сард багтаан байгууллагын албан хаагчдын албан тушаалыг тус бүрээр шинэчлэн боловсруулж, танилцуулж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Батхүү)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ГАНТУЛГА

